



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/375

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо Жуулчны гудамж (8 шаргын урд талд) жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих ажлын байр, борлуулалтын төв байгуулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хэлцэл хийж газар чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн дарга

Гишүүд

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөлтийн гуравдугаар хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Дүүргийн 2 дугаар хороодын Засаг дарга

Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга

Дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

1525011163

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг дүүргийн Засаг даргад тухай бүр танилцуулж, холбогдох арга хэмжээ авахыг Ажлын хэсэг (Ч.Болормаа)-т үүрэг болгосугай.

3.Дээрх ажлыг зохион байгуулахад шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ